

ӨНДӨРШИЛ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН АЖИЛТАНУУДЫН МЭДЛЭГ БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ЗОХИОСОН АЖИЛ

2018 он



Соёлын ажилтануудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд дэмжин ажиллаа.

Дуу хөгжмийн багш б.Үнэнбаяр,галч Ш,Үйтүмэн нарыг МСҮТ цахилгаан болон сантехникийн мэргэжлийн 1 сургалтанд хамруулж мэргэжилтэй болголоо.



Сумын ИТХ-ын хурлаас зохион байгуулагдсан ТАХ-дынхаа мэдлэг боловсролоо дээшлүүлэх зорилгоор Улаанбаатар хотын Хувь хүний хөгжлийн институтэй хамтран зохион байгуулсан “Амжилтын хөтөч” 1 өдрийн сургалтанд – соёлын төвийн эрхлэгч, номын санч, Гурван сайхан суманд зохион байгуулагдсан Зүүн бүсийн ТАХ-ын дунд зохион байгуулагдсан Амжилтын эзэд “ сургалтанд дуу хөгжмийн багш тус тус хамрагдан мэдлэг боловсролоо дээшлүүлэн ажиллаа. Үндэсний номын сан, С.Буяннэмэхийн нэрэмжит Аймгийн Төв номын сан хамтарсан, Monbiblo програмын ашиглалтын талаар сургалтанд номын санчийг хамруулан байгууллагаас зардлыг гарган ажиллаж байна.



Нийт 10 удаагийн сургалтанд дав тоогоор 15 ажилтан хамрагдаж мэргэжил боловсрол, ур чадвар, урын сангаа баяжуулан ажилласан. Соёлын ажилтануудын мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд нь цалинтай чөлөө, томилолтыг олгож суралцах боломжоор хангасан.

Ажилтан нартаа тогтмол ХАБ-ын зааварчилгаа өгч ажилладаг. Галч нарт нормын хувцсаар хангаж,Сар бүр нормын сүүг олгож Нийгмийн хамгаалал,

хөдөлмөрийн сайдын 2002 оны 12 сарын 12-ны өдрийн 122 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Ажилтануудыг илүү цагаар ажилласан тохиолдолд ажилласан хоног, цаг хугацаанаас хамаарч цалинтай чөлөө олгож амрааж, эрүүл мэндийн үзлэг, сорилд ажилтануудаа 100 хувь хамруулсан.

Дуу хөгжим багш, номын санч нарыг мэргэжилтэй болгохоор СУИС-ийн



эчнээ ангид бүртгүүлж 2019 оны 1 сараас эхлэн суралцуулахаар болов.

Байгаль, эх дэлхийгээ аврах тэнгэрлэг аян"-ы тэргүүн Дамдинсүрэнгийн Наранцогтын санаачилгаар зохион байгуулсан ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн "Тулга" хайр халамжийн холбооны



урилгаар Шилийн гол аймагт айлчласан. Аяллын бүрэлдүүнд албан байгууллагуудын эрхлэгч нар оролцсон юм.Шилийн гол аймгийн "Тулга" хайр халамжийн холбооноос ахмад настны дунд зохион байгуулдаг олон талт ажил, 20000 суралцагчтай Ажил мэргэжлийн дээд сургууль, Өү-Яа эмнэлэг, Адууны соёлоор дамжуулан сургалт, хүмүүжлийн

ажлаа явуулдаг үндэсний хэмжээний цорын ганц сургууль-Монгол бага сургууль,Чингэс номын сан, малчин Ялалтын ажил амьдрал зэрэгтэй танилцаж туршлага судлан ажиллаа

Ажилтануудынхаа ажлын үр дүнг тооцох буюу 100 баллын системийг журмыг боловсруулан баталгаажуулж улирал бүр, хагас бүтэн жилээр дүгнэж үр дүнг тооцон ажиллаа. Жилийн эцсээр цалингийн сангаас хамаарч 25-45 хувийн урамшуулалыг ажилтан нарт 100 хувь олгож оны шилдэг ажилтан, оны шилдэг авьяастанаа тодорзуулан алдаршуулж ажилласан.

Манай хамт олон дотроос Төрийн дээд одон медаль Алтан гадас одон-1, хөдөлмөрийн медальт-1, Соёлын гавьяа одон-2, Аймгийн хүндэт дэвтэрт -1 ажилтаны нэр бичигдэж,Аймгийн хүндэт тэмдгээр-1, Аймгийн Засаг даргын жуух бичгээр-1, Хүүхэд гэр бүл хөгжлийн үндэсний газрын Тэргүүний залуу Алтан медаль-1, Сумын жуух бичгээр-1 тус тус шагнагдав.

Аймаг, сумын Төрийн албан хаагчдын манлайлал чуулга уулзалтанд соёлын төвийн удирдлага, ажилтануудыг бүрэн хамруулж оролцуулсан. Тус чуулганаар



Шинээр батлагдсан Төрийн албаны хуулийг танилцуулж, МУ-ын зөвлөх багш Ж.Эрхэмбаяр Төрийн албаны манлайлал ,ТАХ-ын ёс зүй, харилцаа , ажлын бүтээмж сэдэвт сургалтыг зохион байгуулагдав. Соёлын төвийн хамт олон ТАХ нарт Тойром бүжиг , дууг зааж нийт 125 хүн хамрагдав.

Ажилтануудаас ажлын байрны таата орчны сэтгэл ханамжийн судалгааг асуулгаар болон харилцан

ярилцлагаар 2 удаа зохион байгуулсан . Үүний үр дүнд

Соёлын төвдөө 2018 оны эцсээр 9667 000 сая төгрөгний хөрөнгө оруулалтын ажлыг хийлээ.

1. Орон нутаг судлах танхимыг камержуулан дохиололын системтэй болгон, хөгжим техник хэрэгсэл аппаратурыг шинэчилсэн.
2. Соёлын ажилтануудын бичиг хэргийн албыг явуулахад өнгөт, хар принтерээр хангаж, дэлгэц , проектор, видео , зургийн аппарат болгон ТС хөдлөх , биет бус өвийг баримтжуулан ажиллах техник хэрэгсэлээр хангалаа.

Иргэд залуучуудын чөлөөлт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, дуулах үр чадварыг хөгжүүлэх, урын санг баяжуулах зорилготойгоор орчин үеийн караоке иж бүрдэл техник хэрэгсэлээр ханган үйл ажиллагаа явуулах техникийн нөхцлийг тус тус бүрдүүлээ.



СОЁЛЫН ТӨВ